



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2019/9/СТА-ТШЗ**

Баянхонгор хот 2019 он



Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024

Цахим хаяг: [tsetsegmaadam@audit.gov.mn](mailto:tsetsegmaadam@audit.gov.mn)

Аудитор:

Б.Цэрэнчимэд.

Утас: 88302569

Цахим хаяг: [tserenchimedb@audit.gov.mn](mailto:tserenchimedb@audit.gov.mn)

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1.	Оршил .....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.8.2.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.10.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Э.НАНДИНБИЛЭГ  
ТАНАА

2019.02.25 № 2/71  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т  
Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм

D:\СТА-2018\Баянбулаг ЕБСургууль\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

7519123

хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\СТА-2018\Баянбулаг ЕБСургууль\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Э.Нандинбилэгт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 20-ноос 2019 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 2.1-т заасны дагуу ерөнхий боловсролын суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд сургалтын үйл ажиллагааг чиглүүлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп ХХК-ий “Acolous” программ хангамж ашигладаг байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 487100,3 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 9742,0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	0.50	Урьдчилгаанд олгосон цалин дутуу суутгасан
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	0.50	

**2.8.1. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 453378,1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2018 онд улсын төсвөөс 452878,1 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоор 500,0 мянган төгрөг, нийт 453378,1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 453275,9 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 102,1 мянган төгрөг хэмнэж буцаан төвлөрүүлсэн байна.

**2.8.2. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### **2.8.2.1 Балансын данстай холбоотой асуудал**

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай үүссэн тооцоог нийлж үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. 2018 оны эцэст авлагагүй, 14,4 мянган төгрөгийн өглөгтэй тайлан гарсан байна. Харин Э.Нандинбилэгт 1930.0 мянган төгрөгийн урьдчилгаа олгож, цалингаас нь 1430,0 мянган төгрөг суутгаж, 500,0 мянган төгрөг үлдсэн байхад балансад авлагаар бүртгээгүй зөрчил байна.

Энэ нь “оршин байх”, гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ-ийн тухай хуулийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ", 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, **авлага**" гэж заасан заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймээс Э.Нандинбилэгт олгосон цалингийн урьдчилгаанаас дутуу суутгасан 500,0 мянган төгрөгийг төлүүлэхээр шийдвэрлэж, төлбөрийн акт тогтоолоо.

### **2.9. Шилэн дансны мэдээлэл**

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлогын 31 гүйлгээ, зарлагын 7 гүйлгээ байгааг хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

### **2.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдөж, 100,0 хувь биелүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.11. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНБОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу

материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>46,556,560.60</u></b>	<b><u>47,551,113.60</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	7,197.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	7,197.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	7,197.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	46,549,363.60	47,551,113.60
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	3,370,150.00	3,370,150.00
35110	Тусгай зориулалттай материал	3,370,150.00	3,370,150.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	42,280,213.60	43,281,963.60
35420	Аж ахуйн материал	14,014,400.00	14,284,400.00
35440	Түлш, шатах тослох материал	1,026,650.00	225,000.00
35460	Хүнсний материал	495,000.00	640,800.00
35470	Бусад хангамжийн материал	26,744,163.60	28,131,763.60
35600	Мал амьтад	899,000.00	899,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>409,261,309.48</u></b>	<b><u>644,275,423.51</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	409,261,309.48	644,275,423.51
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	409,261,309.48	617,499,423.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	600,719,072.00	583,196,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-259,324,738.02	-25,492,416.82
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	132,501,933.60	133,701,933.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-99,258,546.04	-111,631,556.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,538,685.23	69,184,385.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,264,028.20	-50,765,352.62
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,659,000.00	6,009,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,619,091.29	-2,219,991.23
39217	Ном	15,309,022.20	15,516,822.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.00	26,776,000.00
39301	Програм хангамж	875,000.00	875,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-875,000.00	-875,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	26,776,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>455,817,870.08</u></b>	<b><u>691,826,537.11</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>19,378.00</u></b>	<b><u>14,399.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	19,378.00	14,399.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	19,378.00	14,399.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>455,798,492.08</u></b>	<b><u>691,812,138.11</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	455,798,492.08	691,812,138.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	390,612,192.00	417,388,192.00
51101	Өмч: - төрийн	390,612,192.00	417,388,192.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-159,616,446.76	-179,353,528.89

51210	Өмнөх үеийн үр дүн	-159,616,446.76	-159,616,446.76
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-19,737,082.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	224,802,746.84	453,777,475.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>455,817,870.08</b>	<b>691,826,537.11</b>

### 3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>499,555,142.00</b>	<b>467,363,188.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,896,000.00</b>	<b>8,806,100.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,896,000.00	8,806,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,896,000.00	8,806,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,396,000.00	8,306,100.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>19,256,942.00</b>	<b>5,678,988.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	474,402,200.00	452,878,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,200,400.00	1,387,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,200,400.00	1,387,600.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	9,936,360.00	00.00
133003	Хөрөнгийн	9,936,360.00	00.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	3,120,182.00	4,291,388.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,120,182.00	4,291,388.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>497,135,214.93</b>	<b>487,100,270.13</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>497,135,214.93</b>	<b>487,100,270.13</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	459,670,442.93	458,067,271.13
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	283,328,840.00	288,494,507.00
210101	Үндсэн цалин	216,490,940.00	222,400,428.00
210102	Нэмэгдэл	28,210,500.00	28,268,690.00
210104	Урамшуулал	19,686,000.00	18,433,989.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,941,400.00	19,391,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,118,200.00	34,002,600.00
210201	Тэтгэврийн даатгал	31,118,200.00	22,250,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,210,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,263,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	565,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	5,713,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	47,513,428.00	45,923,750.00
210301	Гэрэл, цахилгаан	2,548,278.00	3,415,500.00
210302	Түлш, халаалт	43,024,250.00	40,708,250.00
210303	Цэвэр, бохир ус	1,940,900.00	1,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,922,110.00	7,784,000.00
210401	Бичиг хэрэг	883,520.00	731,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,168,000.00	5,256,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	997,890.00	406,900.00
210404	Ном, хэвлэл	278,800.00	359,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,593,900.00	1,030,000.00

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	40,091,400.00	42,543,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	334,100.00	269,800.00
210502	Хоол, хүнс	39,147,000.00	41,489,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	610,300.00	783,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,911,600.00	1,782,300.00
210604	Урсгал засвар	2,911,600.00	1,782,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	660,800.00	318,600.00
210702	Дотоод албан томилолт	660,800.00	318,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,870,782.00	288,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,870,782.00	288,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	43,253,282.93	36,930,414.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,335,400.00	1,994,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	5,795,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,517,882.93	29,140,114.13
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	37,464,772.00	29,032,999.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	37,452,800.00	28,930,888.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	4,291,388.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,211,500.00	17,145,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,849,400.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,887,400.00	6,887,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,504,500.00	607,100.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	11,972.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,972.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	102,111.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	102,111.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>2,419,927.07</b>	<b>-19,737,082.13</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>2,419,927.07</b>	<b>-19,737,082.13</b>

### 3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>484,222,782.00</b>	<b>459,057,088.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	500,000.00	500,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	500,000.00	500,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	500,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>483,722,782.00</b>	<b>458,557,088.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	474,402,200.00	452,878,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,200,400.00	1,387,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,200,400.00	1,387,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	3,120,182.00	4,291,388.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,120,182.00	4,291,388.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>484,222,782.00</b>	<b>458,959,688.00</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>484,222,782.00</b>	<b>458,959,688.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>446,758,010.00</b>	<b>429,926,689.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	282,448,840.00	288,441,289.00
210101	Үндсэн цалин	215,460,940.00	222,427,210.00
210102	Нэмэгдэл	28,860,500.00	28,188,690.00
210104	Урамшуулал	19,686,000.00	18,433,989.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,441,400.00	19,391,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,118,200.00	33,948,000.00
210201	Тэтгэврийн даатгал	31,118,200.00	22,250,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,210,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,263,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,060,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	5,163,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	47,050,078.00	45,410,100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,710,178.00	3,415,500.00
210302	Түлш, халаалт	42,560,900.00	40,194,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,779,000.00	1,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,704,610.00	7,546,000.00
210401	Бичиг хэрэг	856,520.00	731,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,168,000.00	4,968,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	997,890.00	406,900.00
210404	Ном, хэвлэл	1,061,200.00	409,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,621,000.00	1,030,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	43,665,300.00	42,744,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	334,100.00	325,400.00
210502	Хоол, хүнс	39,148,000.00	41,635,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,183,200.00	783,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,921,600.00	1,782,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,300,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,621,600.00	1,782,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	660,800.00	318,600.00
210702	Дотоод албан томилолт	660,800.00	318,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,921,182.00	1,675,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,921,182.00	1,675,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,267,400.00	8,060,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,867,400.00	2,264,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	5,795,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>37,464,772.00</b>	<b>29,032,999.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	37,452,800.00	28,930,888.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	4,291,388.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,211,500.00	17,145,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,849,400.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,887,400.00	6,887,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,504,500.00	607,100.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	11,972.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,972.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	102,111.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	102,111.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	97,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	97,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	97,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	97,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	97,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-97,400.00

### 3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	390,612,192.00	224,802,746.84	-167,110,192.83	448,304,746.01
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	390,612,192.00	224,802,746.84	-167,110,192.83	448,304,746.01
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,419,927.07	2,419,927.07
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	390,612,192.00	224,802,746.84	-159,616,446.76	455,798,492.08
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	390,612,192.00	224,802,746.84	-159,616,446.76	455,798,492.08
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	228,974,728.16	00.00	228,974,728.16
Тайлант үеийн үр дүн	26,776,000.00	00.00	-19,737,082.13	7,038,917.87
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	417,388,192.00	453,777,475.00	-179,353,528.89	691,812,138.11

### 3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	453,378,100.00	453,275,989.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	453,378,100.00	453,275,989.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	428,738,600.00	428,636,489.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,592,800.00	288,491,289.00
210101	Үндсэн цалин	220,654,900.00	222,477,210.00
210102	Нэмэгдэл	28,860,500.00	28,188,690.00
210104	Урамшуулал	19,686,000.00	18,433,989.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,391,400.00	19,391,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,947,000.00	33,948,000.00
210201	Тэтгэврийн даатгал	22,631,500.00	22,250,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,828,900.00	3,210,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,263,100.00	2,263,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	565,800.00	1,060,800.00

210205	Эрүүл мэндийн даатгал	5,657,700.00	5,163,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45,410,100.00</b>	<b>45,410,100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,415,500.00	3,415,500.00
210302	Түлш, халаалт	40,194,600.00	40,194,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,593,400.00</b>	<b>7,593,400.00</b>
210401	Бичиг хэрэг	676,900.00	731,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,968,000.00	4,968,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	406,900.00	406,900.00
210404	Ном, хэвлэл	511,600.00	456,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,030,000.00	1,030,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>42,744,500.00</b>	<b>42,744,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	269,800.00	325,400.00
210502	Хоол, хүнс	41,744,100.00	41,635,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	730,600.00	783,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,782,300.00</b>	<b>1,782,300.00</b>
210604	Урсгал засвар	1,782,300.00	1,782,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>318,600.00</b>	<b>318,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	318,600.00	318,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>289,600.00</b>	<b>288,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	289,600.00	288,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8060300.00</b>	<b>8060300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,264,600.00	2,264,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,795,700.00	5,795,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24639500.00</b>	<b>24639500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,639,500.00</b>	<b>24,639,500.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,145,000.00	17,145,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,887,400.00	6,887,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	607,100.00	607,100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>453,378,100.00</b>	<b>453,275,989.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>452,878,100.00</b>	<b>452,775,989.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	452,878,100.00	452,775,989.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	500,000.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>00</b>	<b>00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>38</b>	<b>38</b>
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	26	26
620003	Үйлчлэх ажилтан	05	05
620004	Гэрээт ажилтан	06	06
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>291</b>	<b>281</b>

630	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	291	281
630001	Төрийн өмчит ЕБС	291	281